

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
ТОГТООХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 болон 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны эрсдэл даах чадварт зохистой харьцаа тогтоох, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.2 Банк нь өөрийн үйл ажиллагаанд дараах зохистой харьцааг хангаж ажиллана . Үүнд:
 - 1.2.1.Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа;
 - 1.2.2.Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа.
- 1.3 Банк энэхүү журмын 1.2-т заасан зохистой харьцааны үзүүлэлтийг үнэн зөв тооцож, түүнд үнэлгээ, дүгнэлт хийх замаар үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авна.
- 1.4 Энэхүү журмын 1.2-т заасан зохистой харьцааны доод хэмжээг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.
- 1.5 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилдсөний үндсэн дээр Монголбанк банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, эрсдэлийг харгалзан энэхүү журмын 1.2-т зааснаас гадна нэмэлт зохистой харьцааг тогтоон мөрдүүлж болно.
- 1.6 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.6.1. “Банкны өөрийн хөрөнгө” гэж хувьцаат капитал (ердийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа, халаасны хувьцаа), бусад өмч (нэмж төлөгдсөн хувьцаа, дахин үнэлгээний нэмэгдэл, хандивын капитал), хуримтлагдсан ашиг, алдагдал, хоёрдогч өглөг болон нийгмийн хөгжлийн сангийн нийлбэрийг;
 - 1.6.2. “Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө” нь банкнаас гаргасан энгийн хувьцаа, хугацаагүй, ногдол ашгийг хуримтлуулан тооцдоггүй давуу эрхтэй хувьцаа, халаасны хувьцаа, нэмж төлөгдсөн энгийн хувьцаа, хуримтлагдсан ашиг, алдагдал, цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сангийн нийлбэрийг;

ТӨСӨЛ

- 1.6.3. “Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэж нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцсон хөрөнгөөс бусад давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн давуу эрхтэй хувьцаа, дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан болон 5 жилээс дээш хугацаатай хоёрдогч өглөгийн нийлбэрийг;
- 1.6.4. “Хоёрдогч өглөг” гэж гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хөрөнгө оруулагчдын хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх эх үүсвэрийг.
Хөгжлийн банк нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан эсхүл дампуурсан тохиолдолд банкны активыг *худалдаж* борлуулсан орлогоос нэхэмжлэгчийн шаардлагыг хангах дарааллын "бусад өглөг" гэсэн төрөлд хоёрдогч өглөгийг хамааруулна.
- 1.6.5. “Зээлдэгч” гэж Хөгжлийн банкнаас зээл, санхүүжилт олгосон, баталгаа, батлан даалт гаргуулсан этгээдийг;
- 1.6.6. “Холбогдох этгээд” гэж Монгол Улсын Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан этгээдийг;

ХОЁР. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 2.1 Банкны эрсдэл даах чадварыг өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр үнэлэх бөгөөд дараах зохистой харьцаа тогтооно:
- 2.1.1 Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа;
- 2.1.2 Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа.
- 2.2 Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг энэ журмын 1.6.2-д заасан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 2.4-д заасны дагуу тохируулан 2.5-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.
- 2.3 Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг энэ журмын 1.6.2 болон 1.6.3-д заасан өөрийн хөрөнгийн нийлбэрийг 2.4-д заасны дагуу тохируулан 2.5-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.
- 2.4 Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцохдоо дараах байдлаар тохируулна:
- 2.4.1 Банк болон санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгөд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан оруулсан хөрөнгийн 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна;

ТӨСӨЛ

- 2.4.2 Барьцаанд байгаа өөрийн хөрөнгийн дүнг өөрийн хөрөнгийн харгалзах төрлөөс хасна;
- 2.4.3 Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хэтрэхгүй;
- 2.4.4 Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцох хоёрдогч өглөг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй;
- 2.4.5 Хугацаагүй, ногдол ашгийг хуримтлуулан тооцдоггүй давуу эрхтэй хувьцаа нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд эзлэх хувь нь 15 хувиас хэтрэхгүй;
- 2.4.6 Монголбанкны хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой бусад тохируулагыг хийнэ;
- 2.4.7 Гудвилыг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна.

2.5 Банкны эрсдэлээр жигнэсэн актив дараах бүрэлдэхүүнтэй байна

- 2.5.1 Зээлийн эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.5.2 Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.5.3 Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив.

2.6.3 зээлийн эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцохдоо тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргүүдийн харгалзах эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан эрсдэлийн хувиар үржүүлж гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална.

- 2.6.1 Стандарт энд Пурс (Standard & Poors), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон зээлжих суурь зэрэглэлийг (*baseline*) ашиглан гадаадын банкнаас авах авлагын эрсдэлийн хувь хэмжээ болон гадаадын банкны батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг дараах хүснэгтийг үндэслэн тус тус тооцно;

Стандарт энд Пурс	AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	B- бага	Рейтинггүй банк
Фич						
Муудиз	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
Урт хугацаат авлага (3 сараас дээш)	20%	50%	50%	100%	150%	100%
Богино хугацаат авлага (3 сараас доош)	20%	20%	20%	50%	150%	100%

ТӨСӨЛ

- 2.6.2 Энэ журмын 2.6.1-т заасан 2 болон түүнээс дээш зэрэглэл тогтоох байгууллагаас зээлжих зэрэглэл тогтоолгосон гадаадын банкнаас авах авлага болон түүний батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг тооцохдоо хамгийн доод зэрэглэлийг ашиглана.
- 2.7. Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн активыг “Хамгийн их эрсдэлийн арга”-аар тооцох тусгай зөвшөөрөлгүй аваагүй бол журмын 4.3-т тусгасан нийт нээлттэй позицийн дүнгээр, зөвшөөрөлтэй бол өсөн нэмэгдэх магадлалын 99 хувийн итгэлцлийн түвшинд харгалзах дүнг өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааны доод хэмжээний урвуугаар үржүүлэн тодорхойлно.
- 2.8. Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн активыг банкны сүүлийн гурван жилийн татварын өмнөх эерэг ашгийн дунджийн 15 хувийг өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааны доод хэмжээний урвуугаар үржүүлэн тодорхойлно.

ГУРАВ. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 3.1. Банк харилцагчийн анхны шаардлагаар төлбөр гүйцэтгэх банкны чадварыг хангах, банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор энэ зохистой харьцааг мөрдөнө.
- 3.2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг энэ журмын 3.3-д заасны дагуу тохируулсан түргэн борлогдох хөрөнгийг 3.4-д заасны дагуу тохируулсан гарах мөнгөн хөрөнгөд харьцуулан 2 дугаар хавсралтын дагуу тооцно.
- 3.3. Түргэн борлогдох активыг касс дахь бэлэн мөнгө, Монголбанкинд байршуулсан хөрөнгө, бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, үнэт металл, Монгол банкны болон Засгийн газрын үнэт цаасны дүнгийн нийлбэрээс клирингийн дамжуулалтын саатлын данснуудын үлдэгдлийг хасаж тооцно.
- 3.4. Гарах мөнгөн хөрөнгийн хэмжээг дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцно:
- 3.4.1. Гарах харилцах, хугацаагүй хадгаламж –төсөөлөл;
 - 3.4.2. Гарах хадгаламж –гэрээний дүн;
 - 3.4.3. Буцаан төлөх зээл, эх үүсвэр –гэрээний дүн;
 - 3.4.4. Гэрээний дагуу олгох зээл, хийх хөрөнгө оруулалт –гэрээний дүн;
 - 3.4.5. Бусад төлөгдөх өр төлбөр, өглөг, зардал, худалдан авалт – төсөөлөл, гэрээний дүн.

ДӨРӨВ. ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТТЭЙ ПОЗИЦ

- 4.1. Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор гадаад валютын нээлттэй позиц тооцно.
- 4.2. Нэг гадаад валютын нээлттэй позицийг дор дурдсанаар тооцно:
- 4.2.1. Цэвэр спот позиц буюу тэнцлийн гадаад валютын актив, пассивын зөрүү (*үүнд хуримтлуулж тооцсон хүүг оруулан, цэвэршүүлсэн алт, мөнгөн гулдмайны үнэлгээг гаргахдаа тухайн үеийн спот ханшийг ашиглана*);
- 4.2.2. Тэнцлийн гадуурх гадаад валютын форвард, фьючерс болон свопын арилжаатай холбоотой өглөг авлагын зөрүү (*үүнд свопын хувьд спот арилжаатай холбоотой хэсгийг нь хасаж тооцох бөгөөд ирээдүйд орох, гарах мөнгөн урсгалыг спот ханшаар нь үнэлнэ*);
- 4.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу төлөх нь тодорхой болсон баталгаа, батлан даалт болон бусад тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүргийн дүн;
- 4.2.4. Ирээдүйд хэрэгжих нь тодорхой болсон, гэрээ, хэлцлээр баталгаажсан орлого, зарлагын гүйлгээний зөрүү;
- 4.2.5. Монголбанк биелэгдэх боломжгүй гэж үзсэн санхүүгийн үүсмэл хэлцлийн ирээдүйд үүсэх өглөг, авлагыг нээлттэй позицийн тооцоонд оруулахгүй үлдээх тохируулгыг гүйцэтгэж болно.
- 4.3 Нийт нээлттэй позицийг гадаад валют тус бүрийн хувьд тооцсон урт позицуудын нийлбэр болон богино позицуудын абсолют нийлбэрийн аль их дүн дээр цэвэршүүлсэн алт, мөнгөний нээлттэй позицийн абсолют дүнг нэмж тодорхойлно.
- 4.4 Тооцоонд зөвхөн тайлант үеэс хойш 6 сарын дотор хэрэгжих гадаад валютын деривативууд, батлан даалт, аккредитив, орлого, зарлагын дүнг тусгана. Үүнд Монголбанктай хийсэн хэлцэл хамаарахгүй.
- 4.5 Банк нь “Хамгийн их эрсдэлийн арга”-аар гадаад валютын ханшийн эрсдэлээс үүсэж болох хохирлыг тооцож болно. Энэхүү аргыг ашиглахад банк Монголбанкнаас нэмэлт зөвшөөрөл авна.
- 4.6 “Хамгийн их эрсдэлийн арга” нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж Монголбанк үзвэл тус зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгож болно.

ТАВ. БУСАД ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 5.1. Банк эрсдэлийг удирдах зорилгоор дараах зохистой харьцааг дотооддоо тогтоон мөрдүүлнэ:
- 2.6.2. Нэг эдийн засгийн салбарт олгох зээл, зээлтэй адилтган тооцох активын нийлбэр, нийт зээл, зээлтэй адилтган тооцох активын харьцаа;
 - 2.6.3. Урт хугацаат актив, тогтвортой эх үүсвэрийн харьцаа;
 - 2.6.4. Гадаад валютын ханшийн эрсдэлийн харьцаа.
- 5.2. Энэхүү журмын 5.1 заасан зохистой харьцааг тооцох аргачлал, мөрдөн ажиллах зохицуулалт нь нь олон улсын туршлагад нийцтэй байх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банк өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт тулгуурлан тогтооно. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон тооцох аргачлалд өөрчлөлт оруулах тухай бүр Монголбанкинд мэдэгдэнэ.
- 5.3. Банк дотооддоо мөрдүүлэх үйл ажиллагааны зохистой харьцааны үзүүлэлтүүд нь энэхүү журмын 5.1-ээр хязгаарлагдахгүй.

ЗУРГАА. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨВЛӨРЛИЙН ХЯЗГААРЛАЛТУУД

- 6.1. Банкны нийт зээлийн багц нь өөрийн хөрөнгийн хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй,
- 6.2. Банк нь нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тэдгээрийг банкны том зээлдэгчдэд хамруулна.
- 6.3. Нийт том зээлдэгч , тэдгээрт холбогдогч этгээдүүдэд олгосон зээл, зээлтэй адилтгах хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь Хөгжлийн банкны нийт зээл, зээлтэй адилтгах актив, баталгаа, батлан даалтын нийлбэр дүнгийн 80% хэтрэхгүй байх.
- 6.4. Нийт том зээлдэгч, тэдгээрт холбогдогч этгээдүүдэд олгосон зээл , зээлтэй адилтгах актив, гаргасан баталгаа батлан даалтын талаар мэдээллийг Гуравдугаар хавсралтын дагуу хүргүүлнэ.

ДОЛОО. ТАЙЛАГНАЛ

- 7.1 Банк энэ журамд тусгасан зохистой харьцааг өдөр бүр хангаж ажиллана.
- 7.2 Энэхүү журамд тусгасан болон банкны эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанк болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын төв байгууллагад бичгээр болон цахим системээр ирүүлнэ.
- 7.3 Энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.
- 7.4 Журмын хэрэгжилтэд Монголбанк хяналт тавина.

----- ооОоо -----

ТӨСӨЛ

Хавсралт 1

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН				
				(Гэрбум төгрөгөөр)
				Нийт дүн
	ҮЗҮҮЛЭЛТҮҮД			
A	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ /A1+A11/			
I	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /1+2+3+4/			
1	Хувьцаат капитал /ердийн хувьцаа/			
2	Тухайн жилийн ашиг			
3	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг			
	Дүн			
4	Тохируулгын нэмэгдэх хасагдах гүйлгээ ₁			
II	2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /4+5+6/			
4	Дахин үнэлгээний нэмэгдэл			
5	Хоёрдогч өглөг /5-аас дээш жилийн хугацаатай/			
	Дүн			
6	Тохируулгын нэмэгдэх хасагдах гүйлгээ ₂			
B	ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВЫН ДҮН /B1+B11+B111+B1111/			

		Эрсдэлийн түвшин (%)	Тайлан тэнцлийн	Эрсдэлээр жигнэсэн
I	Активын дүн /1+2+3+4+...+18/			
1	Бэлэн мөнгө	0%		
2	Замд яваа мөнгө	20%		
3	Төв банкин дахь харилцах, хадгаламж	0%		
4	Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас авах авлага /3 сараас доош/	20%		
5	Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас авах авлага /3 сараас дээш/	50%		
6	Гадаадын банк санхүүгийн байгууллагаас авах авлага ₃	20%		
7	Гадаадын банк санхүүгийн байгууллагаас авах авлага ₃	50%		
8	Гадаадын банк санхүүгийн байгууллагаас авах авлага ₃	100%		
9	Гадаадын банк санхүүгийн байгууллагаас авах авлага ₃	150%		
10	Зээлийн өрийн үлдэгдэл			
	10.1 Гадаадын банкнаас гаргасан батлан даалтаар баталгаажсан зээл ₃	20%		
	10.2 Гадаадын банкнаас гаргасан батлан даалтаар баталгаажсан зээл ₃	50%		
	10.3 Гадаадын банкнаас гаргасан батлан даалтаар баталгаажсан зээл ₃	100%		
	10.4 Гадаадын банкнаас гаргасан батлан даалтаар баталгаажсан зээл ₃	150%		
	10.5 Улсын төсвөөс эргэн төлөгдөх зээл	0%		
	10.5 Засгийн газрын баталгаатай зээл	0%		
	10.6 Дотоодын банкнаас гаргасан батлан даалт, векселиэр баталгаажсан зээл	50%		
	10.7 Бусад зээл	100%		
11	Үнэт металл	100%		
12	Төв банкны үнэт цаас ба хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	0%		
13	Засгийн газрын үнэт цаас болон засгийн газрын баталгаатай үнэт цаас	0%		
14	Бусад үнэт цаас	100%		
15	Өмчлөх бусад үндсэн хөрөнгө	100%		
16	Биет ба биет бус хөрөнгө	100%		
17	Бусдаас авах авлага болон урьдчилж төлсөн тооцоо	100%		
18	Бусад хөрөнгө	100%		
19	Деривативын авлага	100%		
II	Тэнцлийн гадуурх дансны дүн /1+2+3+4/			
1	Тендэрийн болон гүйцэтгэлийн батлан даалт	50%		
2	Гадаад худалдааны аккредитивууд	20%		
	а. Гадаад худалдааны аккредитивууд			
	б. Харилцагчийн аккредитивын эх үүсвэр			
3	Урьдчилгаа төлбөрийг буцаах батлан даалт, Стэндбай аккредитив, векселийн батлан даалт (цэврээр буюу а-б)	100%		
	а. Батлан даалтууд			
	б. Батлан даалтын эх үүсвэр			
4	Зээлийн шугам ₄	50%		
III	Гадаад валютын ханшийн эрсдэлийн үзүүлэлт			
IV	Сүүлийн гурван жилийн эерэг ашгийн дундаж			
V	I ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭЖА-ЫН ХАРЬЦАА (A1/B*100%)			
	БАЙВАЛ ЗОХИХ /ХУВИАР/		****	6.00%
	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ		****	
	НЭМЭЛТ ШААРДЛАГАТАЙ I ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		****	
Г	ӨХ, ЭЖА-ЫН ХАРЬЦАА (A/B*100%)			

	БАЙВАЛ ЗОХИХ /ХУВИАР/		ТӨСӨЛ ***	10.50%
	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ		***	
	НЭМЭЛТ ШААРДЛАГАТАЙ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		***	

Хавсралт 2

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ
ЧАДВАРЫН ХАРЬЦАА**

		Тэрбум төгрөгөөр
А	ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ	
1	Бэлэн мөнгө	
2	Монгол банкин дахь харилцах, хадгаламж	
	а. Монгол банкин дахь харилцах, хадгаламж	
	б. Банк хоорондын клирингийн тооцооны саатлын данс	
3	Монгол банкны үнэт цаас	
4	Бусад бакин дахь харилцах, хадгаламж	
5	Засгийн газрын үнэт цаас	
Б	ДАРААГИЙН 30 ХОНОГТ ГАРАХ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	
6	Гарах харилцах, хугацаагүй хадгаламж	
7	Гарах хадгаламж	
8	Буцаан төлөх зээл, эх үүсвэр	
9	Шинээр хийх хөрөнгө оруулалт, олгох зээл	
10	Бусад төлөгдөх өр төлбөр, өглөг, зардал, худалдан авалт	
В	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА А/Б	
Г	БАЙВАЛ ЗОХИХ ХЭМЖЭЭ	100%
Д	НЭМЭЛТ ШААРДЛАГАТАЙ ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВЫН ХЭМЖЭЭ (Г-В)*Б	

